



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/236

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 25 дугаар зүйлийн 25.1.2, 25.2 дах заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 24 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын цахим мэдээллийн сан зохион байгуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гамшгийн шуурхай удирдлагын газар /онцгой байдлын хурандаа Б.Ууганбаяр/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОНГУЙЦЭТГЭГЧ,  
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА БӨГӨӨД ШТАБЫН ДАРГА,  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХУРАНДАА



П.БАТТОГТОХ

007928

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2016 оны 10 дугаар сарын 08-ны  
өдрийн 494 дугаар тушаалын  
хавсралт

## ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь гамшиг, аюулт үзэгдэл, ослын цахим мэдээллийн сан /цаашид "гамшгийн цахим мэдээллийн сан" гэх/-г бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гамшгийн мэдээ, мэдээллийн бодит байдлыг шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч нар хариуцаж, гамшгийн статистикч-судлаач, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн нар өдөр тутмын бүрдүүлэлтэд хяналт тавьж, Гамшгийн шуурхай удирдлагын газар цахим мэдээллийн сан, удирдлагын програм хангамж бүхий сервер компьютерийн техникийн бэлэн байдал, программ хангамжийн найдвартай ажиллагааг тус тус хариуцна.

1.3. Гамшгийн цахим мэдээллийн сангийн өдөр тутмын хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үүднээс үндсэн компьютерийн ажиллагаа доголдоход нөөц компьютер нь нөхөн ажиллах чадвартай мэдээллийн сангийн 2, удирдлагын программ хангамжийн 2 сервер компьютер бүхий байдлаар Онцгой байдлын ерөнхий газрын "Цахим бүртгэл мэдээллийн систем"-ийг ашиглан зохион байгуулна.

### Хоёр. Гамшгийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх

2.1. Гамшгийн цахим мэдээллийн сангийн бүтэц нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/494 дугаар тушаалаар батлагдсан журмын ГМ-1-ээс ГМ-17 дугаар маягтад заасан мэдээллээс бүрдэнэ.

2.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж буй дуудлага хүлээн авагч нар тухайн ээлжийн үүрэг гүйцэтгэх хугацаанд гарсан гамшиг, аюулт үзэгдэл, ослын анхдагч мэдээ, мэдээллийг үүрэн болон суурин утас, факс, цахим шуудан болон бусад мэдээллийн хэрэгсэл ашиглан Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид шуурхай дамжуулна.

2.3. Анхдагч мэдээ, мэдээлэл хүлээн авсан Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч мэдээлэлд дүн шинжилгээ хийн баталгаажуулж "Цахим бүртгэл мэдээллийн систем"-ийг ашиглан мэдээллийг шинээр бүртгэх үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

2.4. Гамшгийн цахим мэдээллийн сангийн мэдээлэлд өдөр тутам баяжилт хийх үүргийг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж буй дуудлага хүлээн авагч нар хүлээнэ.

2.5. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч нар гамшиг, аюулт үзэгдэл, ослын хоногийн мэдээний бүрдүүлэлтэд хяналт тавьж нэгтгэн зөвхөн удирдлагын программ

хангамжаас боловсруулагдсан гамшгийн нөхцөл байдлын хоногийн мэдээний файлаар өдөр бүр Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагад танилцуулна.

2.6. Гамшгийн цахим мэдээллийн санд тухайн гамшгийн улмаас учирсан хохирол, зарцуулсан зардлын мэдээллийг нэмж оруулах үүргийг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, хэрэв тухайн мэргэжилтэн оруулах боломжгүй тохиолдолд гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч хүлээнэ.

2.7. Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэж буй дуудлага хүлээн авагч "Цахим бүртгэл мэдээллийн систем"-ийг ашиглан гамшгийн цахим мэдээллийн санд мэдээлэл оруулах боломжгүй тохиолдолд холбогдох мэдээг Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчид үүрэн болон суурин утас, факс, цахим шуудан болон бусад мэдээллийн хэрэгслээр шуурхай дамжуулна.

### **Гурав. Гамшгийн цахим мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг боловсруулах, түгээх, ашиглах**

3.1. Гамшгийн цахим мэдээллийн санд төвлөрсөн мэдээллийг нэгтгэн боловсруулах, түгээх ажлыг Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төв, Гамшиг судлалын хүрээлэнгийн гамшгийн статистикч-судлаач эрхлэн гүйцэтгэнэ.

3.2. Гамшгийн статистикч-судлаач нь сар бүр мэдээлэлд боловсруулалт хийж, сарын нэгтгэсэн мэдээг дараа сарын эхний 7 хоногийн 2 дахь өдөр Үндэсний статистикийн хороонд цахимаар хүргүүлж зөвшөөрөгдсөн мэдээг өдөр бүр вэб сайтаар иргэд, олон нийтэд түгээнэ.

3.3. Иргэд, олон нийт вэб сайтаар дамжуулан гамшгийн статистик тоон мэдээтэй танилцах боломжтой байна.

3.4. Гамшгийн цахим мэдээллийн сангаас мэдээлэл авч ашигласан тохиолдолд эх сурвалжийг заавал дурдана.

3.5. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын сарын нэгдсэн мэдээг тухайн сарын, улирлын нэгдсэн мэдээг тухайн улирлын сүүлийн сарын, хагас жилийн нэгдсэн мэдээг 6 дугаар сарын, жилийн эцсийн нэгдсэн мэдээг 12 дугаар сарын сүүлийн өдрийг дуусталх хугацаагаар тасалбар болгон тайлагнана.

3.6. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төв нь энэхүү журмын хэрэгжилт, гамшгийн мэдээллийн сангийн ашиглалтын тайлангжил бүр гаргана.

### **Дөрөв. Гамшгийн цахим мэдээллийн санг хадгалах, хамгаалах**

4.1. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төв нь гамшгийн цахим мэдээллийн сантай холбоотой мэдээ, мэдээллийг хадгалах, хамгаалах ажлыг хариуцна.

4.2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор гамшгийн цахим мэдээллийн санг зохион байгуулах, түүний удирдлагын программ хангамжийг бичиж боловсруулах,

хөгжүүлэх явцад хөтлөгдсөн бичиг баримт, холбогдох файл, удирдлагын программ хангамжийн эх код, цахим мэдээллийн сангийн өгөгдлийг Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвд, тус төвөөс 100 км-ээс доошгүй орон зайд орших хадгалалт, хамгаалалтын шаардлага хангасан өрөө тасалгаа, тоног төхөөрөмж бүхий төв, орон нутгийн Онцгой байдлын газарт, эсвэл цахим мэдээллийн системийн хадгалалт, нөөцлөлтийн үйлчилгээ эрхэлдэг эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагад гэрээний үндсэн дээр хадгална.

4.3. Хэрэв удирдлагын программ хангамжид өөрчлөлт орсон бол эх код, хөтлөгдсөн бичиг баримт, холбогдох файлыг өөрчлөлт хийгдсэн даруйд, цахим мэдээллийн сангийн өгөгдлийг сар бүрийн сүүлийн 7 хоногт программ хангамж, техникийн ашиглалт хариуцсан мэргэжилтэн нөөцлөн хадгалах ажлыг хариуцан зохион байгуулна.

4.4. Албаны хэмжээнд гамшгийн цахим мэдээллийн санд мэдээлэл бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах хэрэглэгчийн компьютер болон сервер компьютерийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/182 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын албаны цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам"-ын дагуу хамгаалах арга хэмжээ авна.

4.5. Гамшгийн цахим мэдээллийн сангийн сервер компьютер, дагалдах техник хэрэгсэл, программ хангамжийг засварлах, шинээр нэмж эд анги суурилуулах, өөрчлөх болон шаардлагатай бусад үйлчилгээ хийхдээ программ хангамж, техникийн ашиглалт хариуцсан мэргэжилтний хяналтын дор мэргэжлийн итгэмжлэгдсэн ажилтан гүйцэтгэнэ.

4.6. Гамшгийн цахим мэдээллийн санд "Цахим бүртгэл мэдээллийн систем" ашиглан хандаж буй хэрэглэгчид хэрэглэгчийн нэр, нууц түлхүүр үгтэй байна.

#### **Тав. Эрх, үүрэг, хориглох зүйл**

5.1. "Цахим бүртгэл мэдээллийн систем"-д хандах эрх бүхий хэрэглэгч 6 сар тутамд, санамсар болгоомжгүйгээс систем рүү хандахад ашиглах нууц түлхүүр үгийн нууцлалыг алдсан гэж үзсэн тохиолдолд цаг алдалгүй нууц түлхүүр үгээ шинэчлэх үүрэгтэй.

5.2. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвийн Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, Гамшиг судлалын хүрээлэнгийн гамшгийн статистикч-судлаач нь гамшгийн цахим мэдээллийн сангийн мэдээллийн бодит байдал, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавин энэ асуудлаар төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийг удирдлага, зохицуулалтаар хангах эрх, үүрэгтэй.

5.3. Хэрэглэгчид цаашид гамшгийн цахим мэдээллийн санг боловсронгуй болгох, ашиглалтыг сайжруулах талаар санал боловсруулж Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвд танилцуулан шийдвэрлүүлэх эрхтэй.

5.4. "Цахим бүртгэл мэдээллийн систем"-ийн хэрэглэгчдэд дараах зүйлсийг хориглоно.

- Хэрэглэгчийн нэр, нууц түлхүүр үгээ өөр этгээдэд ашиглуулах:

- Гамшгийн цахим мэдээллийн сан дахь мэдээллийг албаны бус зориулалтаар ашиглах, ашиглуулах, дур мэдэн нийтэд ил болгох;
- Гамшгийн цахим мэдээллийн сан, түүний удирдлагын программ хангамжийг санаатайгаар эвдэх, гэмтээх, хаах;
- Гамшгийн цахим мэдээллийн сан, түүний удирдлагын программ хангамж, мэдээллийн системд компьютерийн вирус тараах;
- Гамшгийн цахим мэдээллийн сан дахь өөрт зөвшөөрөгдсөнөөс бусад аливаа мэдээ, баримтыг өөрчлөх, устгах;
- Ашиглах хүрээг нь хязгаарласан мэдээ, мэдээллийн санд нэвтрэх, нэвтрэх оролдлого хийх;

### **Зургаа. Хяналт тавих, хариуцлага тооцох**

6.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газар хяналт тавина.

6.2. Энэ журмыг зөрчсөн, хэрэгжилтийг зохион байгуулаагүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Онцгой байдлын байгууллагын албан хаагчийн сахилгын дүрэмд заасны дагуу тухай бүр сахилгын шийтгэл ногдуулан, зөрчил дутагдлыг дахин давтахгүй байх арга хэмжээг зохион байгуулна.

6.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан гамшгийн цахим мэдээллийн сан, түүний удирдлагын программ хангамжийн толгой компьютер, техник хэрэгсэлд ноцтой гэмтэл учирсан, их хэмжээний мэдээлэл устсанаас мэдээллийн санг ашиглахад хүндрэлтэй нөхцөл үүссэн, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй задруулсан мэдээ, мэдээлэл нь ноцтой хор уршиг учруулсан, нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэсэн, албаны нэр хүндийг илт гутаасан нь тогтоогдвол тухайн албан хаагчид холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.